

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсныг
дэмжин баталгаажуулах тухай**

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.20, 8.11.26 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк болон “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК нарын хооронд 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр байгуулагдсан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлтэй, №А/СС241204008-6-1 дугаартай “Эх үүсвэргүй аккредитив, баталгааны эрх нээх нэмэлт гэрээ”, №ЗЭНГ/СС241204008-6-1 дугаартай “Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ”, №ЗБ/СС241204008-6-26-1 дугаартай “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны нэмэлт гэрээ”-г тус тус хүлээн зөвшөөрч, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг удирдлага болгон хүчин төгөлдөр байдлыг дэмжин баталгаажуулсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА